

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 25.13-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг 1 дүгээр хавсралт, “Хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн ажиллах журам”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгуулж байхыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд /Л.Энх-Амгалан/, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд /Ц.Баатархүү/ нарт д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД Л.ЭНХ-АМГАЛАН

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ САЙД Ц.БААТАРХҮҮ

Хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл

Дарга:

- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд

Дэд дарга:

- Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл

Гишүүд:

- Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн (зөвшилцсөнөөр)
- Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл;
- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл;
- Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл;
- Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл;
- Хүүхдийн сэтгэл зүйч, сэтгэцийн эмчийн төлөөлөл (Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хүүхдэд үзүүлэх сэтгэл зүйн нөлөөллийн хүрээнд оролцоно)
- Цагдаагийн төв байгууллагын төлөөлөл;
- Хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл;(Хэвлэл мэдээллийн орчин, контент бүтээх, ёс зүйн хэм хэмжээний хүрээнд оролцоно)
- Боловсролын байгууллагын төлөөлөл;(Хүүхдийн хөгжил, сурч боловсрох ба боловсролд хэвлэл мэдээллийн үзүүлэх нөлөөллийн хүрээнд оролцоно)
- Хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын төлөөлөл (Хүүхдийн нүдээр шийдэл санал болгож, тэдний эрхийг хамгаалахад оролцоно)
- Эцэг эх, олон нийтийн төлөөлөл (Орон тооны бус зөвлөлийн шийдвэрийг бодит туршлага дээр үнэлэхэд оролцоно)

Нарийн бичгийн дарга:

- Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөлөл.

Орон тооны бус зөвлөлийн ажиллах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмаар Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.12-т заасан хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/-ийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Зөвлөл нь Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд ажиллах бөгөөд үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон энэхүү журмыг баримтална.

1.3. Зөвлөл нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.11-т заасан цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам болон Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалахад чиглэсэн радио, телевизийн хөтөлбөрийн дүрмийн¹ хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

Хоёр. Орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, зохион байгуулалт

2.1. Зөвлөл нь дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

2.2. Зөвлөлийн гишүүд нь боловсрол, эрүүл мэнд, эрх зүйн асуудал хариуцсан төрийн байгууллага, хүүхэд хамгааллын байгууллага, боловсролын, хэвлэл мэдээллийн байгууллага болон эцэг, эх, олон нийтийн төлөөллөөс бүрдэх бөгөөд зөвлөл олон талт, тэнцвэртэй төлөөллийг хангасан нийт 9-ээс доошгүй гишүүнтэй байна.

2.3. Зөвлөлийн дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.3.1. Зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хуралдаанаас гарсан дүгнэлт, шийдвэрийн биелэлтийн хэрэгжилтэд хяналт тавих;

2.3.2. Зөвлөлийн ээлжит бус хуралдааныг санаачлах;

2.3.3. Зөвлөлийн хуралдаанаас гаргасан шийдвэр, мэдээ мэдээллийг олон нийтэд мэдээлэх, шаардлагатай тохиолдолд хэвлэлийн бага хурал зохион байгуулах.

2.4. Зөвлөлийн гишүүд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.4.1. хариуцсан гомдол, мэдээллийг мэргэжлийн болон ёс зүйн хүрээнд судалж, хараат бус байдлаар шийдвэрлэн, хуралдаанд танилцуулах;

2.4.2. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын талаар санал гаргах;

2.4.3. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан нэмэлт материалыг ажлын албанаас шаардах, танилцах, хэлэлцэж байгаа асуудлаар зарчмын зөрүүтэй байр сууриа илэрхийлэх, хуралдааны тэмдэглэлд тусгуулах;

2.4.4. хуралдааны материал, мэдээллийн эх сурвалжийг зөвшөөрөлгүйгээр хувилах, гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх.

2.5. Зөвлөлийн ажлын албаны үүргийг Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Хүүхдийн эрхийн асуудал хариуцсан нэгж хэрэгжүүлнэ. Зөвлөлийн ажлын албыг зөвлөлийн нарийн бичгийн дарга удирдана.

2.6. Ажлын алба нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.6.1. Зөвлөлд ирүүлсэн мэдээлэл, гомдлыг хүлээн авах;

¹ Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30.1.7а-д заасан дүрэм

2.6.2.гомдлыг шийдвэрлэх талаар санал боловсруулах гишүүдэд хуваарилж, шийдвэрлэлтэд дэмжлэг үзүүлэх;

2.6.3.Зөвлөлийн хуралдааны бэлтгэл хангах, хуралдааныг зохион байгуулах, хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

2.6.4.Зөвлөлөөс зохион байгуулж буй ажил, түүний явц, үр дүнгийн талаар олон нийтийг мэдээллээр хангах;

2.6.5.Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, бусад баримт бичгийг зохих журмын дагуу архивын нэгж болгон хадгалах.

2.7.Зөвлөлийн гишүүдийг санал болгох, нэр дэвшүүлэх асуудлыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний баталсан удирдамжийн дагуу шийдвэрлэнэ. Энэ удирдамжид нэр дэвшүүлэх төлөөлөл, нэр дэвшигчдийг Засгийн газарт санал болгох асуудал хариуцсан хороо буюу ажлын хэсэг, нэр дэвшигчдийг үнэлэх, сонгон шалгаруулах арга, шалгуур үзүүлэлтийг тусгана.

2.8.Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр хуралдаан байх бөгөөд хуралдааныг танхим, цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулна.

2.9.Зөвлөлийн нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь оролцсоноор хуралдаан хүчинтэй болно.

2.10.Зөвлөлөөс гарах шийдвэр, дүгнэлтийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар гаргах ба санал тэнцсэн бол тухайн асуудлаар татгалзсан шийдвэр, дүгнэлт гарсанд тооцно.

2.11.Хуульд зааснаас бусад тохиолдолд ирсэн гомдол, мэдээлэл, Орон тооны бус зөвлөлийн хэлэлцсэн мэдээлэл, гаргасан шийдвэрийн нууцыг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасны дагуу хамгаална.

2.12.Зөвлөлийн ажлын албанд Цагдаагийн байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороо, Сэтгэцийн эрүүл мэндийн төв, Боловсролын мэдээлэл технологийн төв зэрэг холбогдох мэргэжлийн байгууллагууд туслалцаа үзүүлж хамтран ажиллана.

Гурав. Хүүхдэд хортой агуулгын шалгуурыг тогтоох

3.1.Зөвлөлөөс хүүхдэд хортой агуулгын талаарх иж бүрэн, нарийвчилсан шалгуурыг хүүхдийн насны онцлог, хүчирхийлэл, мөлжлөг, ялгаварлан гадуурхалт, хор хөнөөлтэй хэвшмэл ойлголт зэрэг хүчин зүйлсэд нийцүүлэн баталж олон нийтэд нээлттэй байлгана.

3.2.Энэ журмын 3.1-т заасан шалгуурыг боловсруулахдаа Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам, “Өргөн нэвтрүүлэгт насны ангилал тогтоох, таних тэмдэг ашиглах шаардлага” MNS 6587:2020 стандарт² болон Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 62 дугаар тогтоолын хавсралт “Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах радио, телевизийн хөтөлбөрийн дүрэм”³-ийг тус тус баримтална.

Дөрөв. Хүүхдэд хортой агуулгын талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах, шалгах

4.1.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т заасан хүүхэд хамгааллын удирдлага, зохион байгуулалтын бүрэлдэхүүн байгууллагаас шилжүүлсэн болон иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүүхдэд хортой агуулгын талаарх гомдол, мэдээллийг Зөвлөл хүлээн авна.

² https://estandard.gov.mn/website/masm/standards_details.aspx?code=8dd0fd6b-ff45-42c8-a2ec-c5efb52bd563

³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16381537306261>

4.2.Энэ журмын 4.1-т заасан гомдол, мэдээлэл хүлээн авах суваг нь төлбөргүй буюу хямд төлбөртэй дуудлагын утас, онлайн платформ, бичгээр гаргасан гомдол, мэдээллийг хүлээн авах мэйл хаяг, шуудангийн хаяг байх ба нэргүйгээр буюу зохиомол нэр хэрэглэн гомдол, мэдээлэл гаргах боломжийг бүрдүүлсэн байна.

4.3.Энэ журмын 4.2-т заасан суваг нь гомдол, мэдээллийг дараах мэдээллийг тусгасан маягтын дагуу хүлээн авна:

4.3.1.гомдол, мэдээлэл гаргагчийн мэдээлэл (заавал биш);

4.3.2.хүүхдэд хортой гэж үзэж буй агуулгыг түгээсэн/нэвтрүүлсэн огноо, үргэлжилсэн хугацаа;

4.3.3.хортой агуулгын талаарх дэлгэрэнгүй тайлбар;

4.3.4.хортой агуулгыг гаргасан хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгч;

4.3.5.холбогдох нотлох баримт (баримтжуулсан зураг, цахим холбоос гэх мэт).

4.4.Энэ журмын 4.3-т заасан маягтыг хэрэглэгч, иргэн, хуулийн этгээдийн хэрэгцээнд нийцүүлж хэлний сонголт, цаасан, цахим зэрэг олон янзын форматтай байлгана.

4.5.Гомдол, мэдээллийг хүлээн авсан талаар болон Орон тооны бус зөвлөлөөс хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар гомдол, мэдээлэл гаргагчид даруй мэдэгдэнэ.

4.6.Гомдол, мэдээлэл бүр дугаар өгч, батлагдсан шалгуурын дагуу үнэлж яаралтай, ноцтой байдлаар нь ангилна.

4.7.Гомдол, мэдээллийг хүлээн авсны дараа ажлын алба энэ журмын 3.1-д заасан шалгуурын дагуу шалгаж үзэн Зөвлөлийн гишүүнд даруй хуваарилах ба хариуцсан гишүүн нь шаардлагатай бол нэмэлт нотлох баримт цуглуулах, бүрдүүлэх зэргээр гомдол, мэдээллийг 7 хоногийн дотор шалгана.

4.8. Энэ журмын дагуу 4.7-д заасны дагуу гомдол, мэдээллийг шалгахад зөвлөлийн гишүүнд ажлын алба болон энэ журмын 2.12-д заасан байгууллага нь мэргэжлийн туслалцаа үзүүлж хамтран ажиллана.

4.9.Энэ журмын 4.7-д заасны дагуу гомдол, мэдээллийг шалгахдаа хууль сахиулах байгууллага, хэвлэл мэдээллийн зохицуулалтын байгууллага зэрэг эрх бүхий байгууллагатай зохих ёсоор хамтран ажиллаж болно. Энэ тохиолдолд гомдол, мэдээлэл шалгах хугацааг Орон тооны бус зөвлөлийн даргын зөвшөөрлөөр ажлын 5 хүртэл хоногоор сунгаж болно.

4.10.Гомдол, мэдээллийг судлах, шалгах буюу Орон тооны бус зөвлөлөөс хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар тухай бүр гомдол, мэдээлэл гаргагчид мэдээлэл өгнө.

Тав. Хүүхдэд хортой агуулга эсэх талаар дүгнэлт гаргах

5.1.Орон тооны бус зөвлөлийн гишүүн гомдол, мэдээллийг шалгаж дууссаны дараа энэ журмын 3.1-т заасан шалгуурын хангасан эсэх талаарх саналаа Зөвлөлийн нарийн бичгийн даргад хүргүүлнэ.

5.2.Энэ журмын 5.1-т заасан саналыг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор Орон тооны бус зөвлөл хуралдаж хүүхдэд хортой агуулга эсэх талаар дүгнэлт гаргана.

5.3.Энэ журмын 5.2-т заасан дүгнэлтийг гаргахад шаардлагатай тохиолдолд хүүхдийн хөгжлийн мэргэжилтэн, сэтгэл зүйч болон бусад холбогдох мэргэжилтнүүдийн саналыг авч болно.

5.4.Энэ журмын 5.2-т заасан дүгнэлтийг хурал болсноос хойш 3 хоногийн дотор бичгээр албажуулж, гомдол, мэдээлэл гаргагч болон эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

Зургаа. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ

6.1. Орон тооны бус зөвлөл хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

6.1.1.хүүхдэд хортой агуулга түгээсэн нь тогтоогдсон хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчдэд анхааруулах системийг нэвтрүүлэх;

6.1.2.Орон тооны бус зөвлөлийн дүгнэлтийн дагуу хүүхдэд хортой агуулгыг устгах талаар хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчдэд мэдэгдэл хүргүүлэх, хэрэгжилтийн тайлантай танилцах;

6.1.4.Орон тооны бус зөвлөл дангаараа болон төрийн байгууллага, хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчны үйлчилгээ эрхлэгч, сургууль, олон нийтийн байгууллагатай хамтран хүүхдэд хортой агуулгыг таньж, мэдэх болон тус зөвлөлд гомдол, мэдээлэл гаргах талаар олон нийтэд таниулах үйл ажиллагааг зохион байгуулах;

6.1.5.хүүхдэд хортой агуулгаас сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын сүлжээний үйл ажиллагаанд оролцох ба бусад улсын ижил, төстэй байгууллагатай хамтран ажиллана.

6.2.Зөвлөлийн үйл ажиллагааны зардал, гишүүдэд олгох урамшууллыг Хүүхэд хамгааллын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2, 52.3-т заасны дагуу улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ.

Долоо. Ил тод байдал, эгэх хариуцлага

7.1.Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг жил бүр гаргаж, ирүүлсэн гомдол, мэдээллийн тоо, гаргасан шийдвэр, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тухай олон нийтэд мэдээлнэ.

7.2.Зөвлөлийн дүгнэлтийг эс зөвшөөрч хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчны үйлчилгээ эрхлэгч болон гомдол, мэдээлэл гаргагчийн зүгээс тус зөвлөлд өөрт нь давж заалдах гомдол гаргаж болно. Энэ гомдлыг энэ журмын 4, 5-т заасан дарааллаар шийдвэрлэнэ.

7.3.Орон тооны бус зөвлөлийн үр дүнтэй, хариуцлагатай байдлыг хангах үүднээс гомдол, мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэхэд оролцож буй ажилтан, зөвлөлийн гишүүдийг гомдол, мэдээллийг зөв үнэлж, дүгнэх, түүний агуулгатай холбоотойгоор сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр тогтмол сургалтад хамруулна.

7.4.Өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх үйл явцыг тогтмол үнэлж, шаардлагатай зохицуулалтыг хийнэ.